“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК-ИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025.02.05 Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Биелэлт	Хэрэгжилт/ хувь
Зорилт 1. Хүний нөөцийн стратеги, бодлого, төлөвлөлтийг сайжруулах					
1.1	Компанийн хүний нөөцийн үйл ажиллагаанд баримтлах баримт бичиг, дүрэм журмыг хүний нөөцийн стратеги, бодлого төлөвлөлтийн хүрээнд шинэчлэн сайжруулж мөрдүүлэх	Хийгдсэн ажлууд	Шинээр батлагдсан, нэмэлт, өөрчлөлт орсон хуулиуд, холбогдох журамд нийцүүлэн компанийн хүний нөөцийн үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмыг шинэчилж, хэрэгжилтийг ханган ажилласан. Тухайлбал, 2023 онд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн компанийн “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”, “Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж батлсан.	Компанийн хүний нөөцийн үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмыг шинэчлэх ажлын хүрээнд Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01, 12 дугаар сарын 19-ний өдрийн А/33 дугаар тушаалаар компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг, 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/06, 12 дугаар сарын 31-ний өдрийн А/37 дугаар тушаалаар “Ажил төлөвлөх, гүйцэтгэлийг тайлагнах, үнэлэх журам”-ыг тус тус шинэчлэн батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
1.2	Компанийн бүтэц, орон тоонд нийцүүлэн хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, албан тушаалын тодорхойлолтын шаардлагын дагуу ажлын байрны сул орон тоо, хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, тоо, үр дүн	Компанийн бүтэц, орон тооны хүрээнд нэн түрүүнд шаардлагатай сул орон тооны сонгон шалгаруулалтыг компанийн “Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулж ажил үүргийн хэвийн байдлыг ханган ажилласан ба 2023.12.31-ний өдрийн байдлаар Хүндэт зочны албаны үйлчилгээнд 18, Санхүү, захиргаа удирдлагын хэлтэс болон Нисэх буудлын зохицуулалтын хэлтэст 13, нийт 31 ажилтан байна.	Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлагдсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны хүрээнд 2024 онд Үйлчилгээний туслах ажилтан, Үйлчилгээний ажилтан, Санхүүгийн шинжээч, Тооцооны нягтлан бодогч, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга гэсэн нийт 5 сул ажлын байрны сонгон шалгаруулалтыг нээлттэй явуулж, компанийн “Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу, тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан нийт 12 ажилтныг сонгон шалгаруулж, Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, хугацаагүй Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулав.	100
1.3	Зам, тээврийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын	Мэдээллийг шинэчилсэн удаа, тоо дүн	“Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем”-ийг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ”-д нэгдэж салбарын хүний нөөцийн мэдээллийг нэгтгэхэд 2022 оноос эхлэн компанийн хүний нөөцийн	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 04 дугаартай албан даалгаврын дагуу Салбарын хүний нөөцийн мэдээллийг нэгтгэх ажлын хүрээнд “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ” (ttps://www.platform.mrtd.gov.mn/login)-д үндсэн ажилтнаар томилогдон хугацаагүй хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй нийт 28 ажилтны мэдээллийг бүрэн оруулсан.	100

	2023 оны 04 дугаартай албан даалгаврын дагуу Салбарын хүний нөөцийн мэдээллийг нэгтгэх ажлын хүрээнд "Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ"-д компанийн хүний нөөцийн дэлгэрэнгүй мэдээллийг бүрэн оруулж мэдээллийн санг шинэчилж байх.		мэдээллийг цахим мэдээллийн нэгдсэн санд оруулж эхэлсэн. Хүний нөөцөд өөрчлөлт орсон тухай бүр мэдээллийг тогтмол шинэчилж байгаа ба 2023.12.31-ний өдрийн байдлаар компани нийт 31 ажилтантай, үүнээс компанийн удирдах 3 албан тушаалтан болон туршилтын хугацаагаар шинээр ажилд орсноос бусад 24 үндсэн ажилтны мэдээлэл https://www.platform.mrtd.gov.mn платформд бүрэн орсон.		
Зорилт 2. Хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэх, ажилтны ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх					
2.1	Компанийн хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах, мэргэшүүлэх, ажлын гүйцэтгэл, үр дүн, бүтээмжийг дээшлүүлэх, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн сургалт хөгжлийн төлөвлөгөө боловсруулан батлан, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Хэрэгжилтийн хувь, сургалтын үр дүн	2023 онд компанийн хүний нөөцийн сургалтын арга хэмжээний төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу ажилтныг сургах, давтан сургах, ажил мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр нийт 7 төрлийн 62 академик цагийн танхимын сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулж, компанийн ажилтнуудыг бүрэн хамруулав.	"ХХНОБ" ТӨХХК нь 2024 оны батлагдсан бүтэц, орон тоонд нийцүүлэн ажлын байр, ажил үүргийн хуваарийг оновчтой төлөвлөн, зохион байгуулж, хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх зорилт тавьсан. Энэ хүрээнд компанийн 2024 оны Хүний нөөцийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хүний нөөцийн стратеги, бодлого, төлөвлөлтийг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэх, ажилтны ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах үндсэн 3 зорилтын хүрээнд нийт 9 багц ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн төлөвлөгөөг 2024.02.15-ны өдөр Гүйцэтгэх захирлаар батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 17 төрлийн сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулж хамрагдвал зохих ажилтнуудыг бүрэн хамруулснаар төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хангав.	100
2.2	Ажилтан ажил мэргэжил, албан тушаалын хүрээнд мэргэшлээ ахиулах, мэргэшлийн заавал болон давтан сургалтад хамрагдах, шалгалт өгөх боломж нөхцөлийг хангаж, дэмжлэг үзүүлж ажиллах	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, тоо, үр дүн	Ажилтан ажил мэргэжил, албан тушаалын дагуу мэргэших, мэргэшлийн заавал болон давтан сургалтад хамрагдах, мэргэшлийн шалгалт өгөх зэрэг тохиолдолд цалинтай чөлөө олгох, мөн ажилтан ажил мэргэжлийн шаардлагаар, ажлын байр, албан тушаалын ажил үүрэгт хамаарах сургалтад хамрагдах тохиолдолд компаниас сургалтын төлбөрийн	Ажил олгогчийн зүгээс компанийн санхүүгийн чадавхад нийцүүлэн ажилтны ажлын байрны онцлог, чиг үүрэгт хамаарах сургалт зохион байгуулах, сурч боловсрох, хөгжих, мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд анхаарч тодорхой заалтуудыг тусган "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг боловсруулж, Гүйцэтгэх захирлын 2024.01.02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар шинэчлэн батлуулав. Тухайлбал, Ажилтан ажил мэргэжлийн шаардлагаар, ажлын байр, албан тушаалын ажил үүрэгт холбоотой хамрагдвал зохих сургалтад суралцах тохиолдолд компаниас сургалтын төлбөрийг, эсвэл төлбөрийн тодорхой хувийн дэмжлэг үзүүлэх (9.5.3), тухайн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан ажилтан гүйцэтгэж буй	100

			тодорхой хувиар дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг "Хөдөлмөрийн дотоод журам"-д тусгаж өгсөн.	ажил мэргэжлийнхээ чиглэлээр орой, эчнээгээр суралцах бол нотлох баримтыг үндэслэн жилд 1 сарын цалинтай чөлөө олгох (6.13.2.5), албан тушаалын чиг үүрэгт хамааралтай ажил мэргэжлээр мэргэших, мэргэшлийн заавал болон давтан сургалтад хамрагдах, мэргэшлийн шалгалт өгөх бол нотлох баримтыг үндэслэн ажлын 15 хүртэл өдрийн цалинтай чөлөө олгох (6.13.2.6). Тайлант онд 3 албан тушаалтныг "Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан"-аар бэлтгэж, цаашид мэргэшүүлэхэд анхааран 2024.02.02-ны өдөр Эдийн засагч, Ерөнхий нягтлан бодогч нарыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдах авах тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга, холбогдох журам, заавартай танилцан, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, тайлагнах үйл явц, үнэлгээний хорооны чиг үүрэг болон бусад анхаарах асуудлаарх "Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт"-д хамруулсан. Мөн "Худалдан авах ажиллагааны хөтөч" НҮТББ-аас зохион байгуулсан Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх танхимын сургалтад ЗУХ-ийн Хуулийн ахлах мэргэжилтэн, Хүндэт зочны албаны Үйлчилгээний ерөнхий менежер нар амжилттай хамрагдаж, 2024.11.15-ны өдөр гэрчилгээ авсан. Хүндэт зочны албаны Үйлчилгээний 4 ажилтныг 2024.04.04-05-ны өдрүүдэд "Бариста" сургалтад хамруулж, мэргэшлийн сертификаттай болгосон.	
2.3	Ажилтнуудыг ажлын бүтээмж, гүйцэтгэл, түүний үр дүнгээр нь дүгнэж үнэлэх, урамшуулал болон хариуцлагын тогтолцоог сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	Ажилтны ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт нь ажилтанд нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал олгох, цалинг нэмэгдүүлэх, албан тушаал ахиулах болон хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох, хариуцлага тооцох үндэслэл болох тухай компанийн "Хөдөлмөрийн дотоод журам", ажилтан, ажил олгогч хооронд байгуулсан Хөдөлмөрийн гэрээ болон албан тушаалын тодорхойлолтод тодорхой тусгаж, хөдөлмөрийн сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хэрэгжилтийг ажлын тайлан, үнэлгээ, нэгжийн удирдлагын хяналтын хэлбэрээр дүгнэн ажиллаж байна.	Ажилтнуудыг ажлын бүтээмж, гүйцэтгэл, түүний үр дүнгээр нь дүгнэж үнэлэх, урамшуулал болон хариуцлагын тогтолцоог сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01, 12 дугаар сарын 19-ний өдрийн А/33 дугаар тушаалаар компанийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг, 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/06, 12 дугаар сарын 31-ний өдрийн А/37 дугаар тушаалаар "Ажил төлөвлөх, гүйцэтгэлийг тайлагнах, үнэлэх журам"-ыг тус тус шинэчлэн баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. Компанийн "Ажил төлөвлөх, гүйцэтгэлийг тайлагнах, үнэлэх журам"-ын дагуу ажилтан ажлын гүйцэтгэл, үр дүнгийн тайланг "Хэлтсийн болон өөрийн ажлын төлөвлөгөөний биелэлт, албан тушаалын чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил үүрэг, Албан тушаалын шаардлагыг бүрэн хангаж, ажил үүргээ хэвийн хэрэгжүүлж буй байдал, ажлын гүйцэтгэл, үр дүн, Компанийн Гүйцэтгэх захирал, Захирлын зөвлөлийн шуурхай хурал, хэлтэс, албаны хурлаас болон хэлтэс, алба, нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Ажлын хариуцлага, сахилга, дэг журам, ажлын цаг ашиглалт, ёс зүйн зөрчил, Идэвх санаачилга, хичээл зүтгэл, шинэ санаачилга хэрэгжүүлэлт, Хөдөлмөрийн бүтээмж, компанид оруулж буй хувь нэмэр, үнэлэхүйц үр дүн" гэсэн	100

				гүйцэтгэлийн үзүүлэлтийн дагуу сар бүр гаргаж, тайлагнан ажилладаг. Харьяалах хэлтэс, албаны дарга/менежер нь ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг улирал, хагас, бүтэн жилээр дараах шалгуур үзүүлэлтүүдээр 100 хүртэл оноогоор дүгнэдэг: - Ажилтан ажлын төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргээ хугацаанд нь, зөрчил дутагдалгүй, бүрэн гүйцэд, чанартай гүйцэтгэж, тайлагнаж танилцуулсан эсэх, биелэлт, үр дүн, - Албан тушаалын тодорхойлолтод заасан мэдлэг, мэргэшил, ур чадварын шаардлагыг хангаж, албан тушаалын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, ажлын бүтээмж, үр дүн хангалттай, хариуцлагатай ажиллаж чадаж буй эсэх, - Компанийн удирдлага, удирдах дээд албан тушаалтнаас өгсөн бүх үүрэг даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, гүйцэтгэлийг тайлагнасан байдал, - Хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, холбогдох бусад дүрэм журмыг хэрэгжүүлсэн байдал, алдаа дутагдал, зөрчил илэрсэн эсэх, - Компанийн болон хэлтэс, алба, багийн, мөн өөрийн хариуцсан ажил үүргийн хүрээнд ажлын бүтээмж, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд бие даан санаачилгатай, идэвх зүтгэлтэй ажилласан, шинэлэг үр дүнтэй арга барил, санал санаачилга хэрэгжүүлсэн байдал, - Албан тушаалын чиг үүргийн хэрэгжилт, хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлийн үр дүн, компанийн үйл ажиллагаа, ажлын үр дүнд оруулж буй хувь нэмэр. 2024 онд нийт 32 ажилтан үнэлэгдсэнээс 28 ажилтан 90-100 буюу "Сайн", 3 ажилтан 80-90 буюу "Хангалттай", 1 ажилтан 70-80 буюу "Хэвийн" үнэлгээ авсан байна. Мөн ажил үүрэгтээ хайнга хандсан, ажлын хариуцлага алдсан, зөрчил дутагдал гаргасан 3 ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль болон компанийн Хөдөлмөрийн дотод журмыг удирдлага болгон Гүйцэтгэх захирлын тушаалаар хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан байна.	
2.4	Ажилтнуудын, ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн ажил, арга хэмжээг жил бүр тогтмол төлөвлөж хэрэгжүүлэх.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, тоо, үр дүн	Жилийн төлөвлөгөөний дагуу 2023 онд Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэгт 22 ажилтан, 5 төрлийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд үйлчилгээний 15 ажилтан жилд 2 удаа тус тус хамрагдсан. Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын танхимын болон цахим сургалтад 28 ажилтан хамрагдсан.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон компанийн 2024 оны Бизнес төлөвлөгөөний дагуу нийт ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нарийвчилсан багцын үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг тайлант оны III улиралд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөн, Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгох сонгон шалгаруулалтын ажиллагааг 2025.06 дугаар сард хуулийн дагуу зохион байгуулж, 2024.07 дугаар сард компанийн нийт ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулсан.	100

Зорилт 3. Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах					
3.1	Ажилтнуудын нийгмийн асуудалд анхаарах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх болон ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн төсөв, хөрөнгө нөөцийг жил бүр тухайн жилийн төсөвт тусгаж ажилтны нийгмийн баталгааг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, тоо, үр дүн	Нийт ажилтны нийгмийн баталгааг хангах, инфляцын нөлөөг бууруулах чиглэлээр 2023.04.25-ны өдрөөс эхлэн Гүйцэтгэх захирлын А/06 дугаар тушаалын дагуу ажилтнуудад хоол, унааны нэмэгдлийг олгож эхэлсэн. Жилийн төлөвлөгөөний дагуу 2023 онд Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэгт 22 ажилтан, үйлчилгээний 15 ажилтан 5 төрлийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд жилд 2 удаа тус тус хамрагдсан.	Компанийн 2024 оны Бизнес төлөвлөгөө, ЭЗҮҮЗТ-ний дагуу нийт ажилтны нийгмийн асуудал, амьжиргааны эх үүсвэрийг дээшлүүлэх, ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэгт хамруулах, үндсэн цалинг нэмэгдүүлэх, хоол унааны хөнгөлөлт олгодог болох, нэн шаардлагатай ажилтанд орон байрны дэмжлэг буюу нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх зэрэг 4 зорилтот ажил, арга хэмжээг төсөвлөн, төлөвлөгөө болон төсвийг 2023.12.21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭХТ-2023/06 дугаар тогтоолоор батлуулсан. Эдгээр зорилтын хүрээнд: - "Цалингийн сүлжээг шинэчлэн батлах тухай" Гүйцэтгэх захирлын 2023.12.28-ны өдрийн Б/98 тоот тушаал батлагдаж 2024.01 дүгээр сараас компанийн нийт ажилтны цалинг 30 хүртэл хувиар нэмэгдүүлсэн. - Компанийн нийт ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэг, шинжилгээнд 2024.07 дугаар сард бүрэн хамруулсан. - Хүндэт зочны албаны нэг ажилтанд шинээр орон сууц анх удаа, зээлээр худалдан авахад байрны урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламж нийт 5 сая төгрөгийг Гүйцэтгэх захирлын Б/103 дугаар тушаалаар 2024.09 дүгээр сард олгосон.	
3.2	Ажилтнуудын цалин хөлсний хэмжээ, цалингийн системийг бодит байдалтай нийцэж буй эсэхийг жил бүр судлан цалин хөлсийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, инфляцын түвшин, бусад хүчин зүйлд нийцүүлэн нэмэгдүүлэх бодлого барьж ажилтны амьдралын баталгааг хангахад анхаарч ажиллах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, тоо, үр дүн	Хувьцаа эзэмшигчдээс баталсан төсвийн хүрээнд Гүйцэтгэх захирлын 2022 оны Б/33 дугаар тушаалаар баталсан цалингийн 3 шатлалтай сүлжээг мөрдөж байна. 2023 онд нийт ажилтны үндсэн цалинг 10-20 хувиар нэмэгдүүлсэн.	Ажилтнуудын цалин хөлсийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, инфляцын түвшин, бусад хүчин зүйлд нийцүүлэн нэмэгдүүлэх "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийн (3.2) хүрээнд Гүйцэтгэх захирлын 2023.12.28-ны өдрийн Б/98 тоот тушаалаар ажилтны цалингийн сүлжээг шинэчлэн батлуулж 2024 оноос эхлэн мөрдөж байна. 2024 онд компанийн нийт ажилтны цалинг 30 хүртэл хувиар нэмэгдүүлсэн.	100

---ooOoo---